



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/12/-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ...	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	10
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	13
3.5.1 Орлогын данс	14
3.5.2 Зардлын данс	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



ХАЛИУН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.МЯНГАНБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 191

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР



07020528

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	935,193.2	1,201,788.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	215,618.7	181,470.2
33	АВЛАГА	333,140.1	438,073.7
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	347,634.4	453,334.5
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	111,310.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	38,800.0	17,600.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,532,086.1	3,300,711.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,532,086.1	3,300,711.7
39200	Биет хөрөнгө	3,455,203.1	3,223,960.7
39300	Биет бус хөрөнгө	76,883.0	76,751.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,467,279.3	4,502,500.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,202.0	11,132.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,202.0	11,132.3
41300	Өглөг	1,202.0	11,132.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,466,077.4	4,491,368.1
51	Засгийн газрын хувь оролцоо	4,466,077.4	4,491,368.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,100,422.3	1,100,422.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,245,425.4	2,296,429.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,120,229.7	1,094,516.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,467,279.3	4,502,500.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (i)	4,259,612.5	3,728,268.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	53,173.9	51,337.2
110	Орлогын албан татвар	43,964.9	40,949.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	43,964.9	40,949.4
113	Хөрөнгийн албан татвар	2,714.0	4,850.0

118	Бусад татвар, төлбөр, хураамж	6,495.0	5,537.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,381,126.3	417,095.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,380,126.3	417,095.2
122	Тусламжийн орлого	1,000.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,825,312.3	3,259,836.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,045,677.8	3,507,087.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,045,677.8	3,507,087.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,156,145.4	2,629,647.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,272,668.4	1,403,361.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,617.9	181,401.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,612.9	262,736.1
2104	Хангамж, бараа материалын зардал	63,364.6	87,968.7
2105	Нормативт зардал	54,366.5	268,114.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,048.1	16,659.2
2107	Томилолт, зочны зардал	4,351.7	4,366.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,941.5	18,301.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	315,173.8	386,739.4
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	889,532.4	877,439.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,213,934.7	221,180.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,724.5	194,389.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,175,210.2	26,791.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,952,936.7	3,256,904.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	53,173.9	51,337.2

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

110	Орлогын албан татвар	43,964.9	40,949.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	43,964.9	40,949.4
113	Хөрөнгийн албан татвар	2,714.0	4,850.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	6,495.0	5,537.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,869.4	3,829.8
1181	Газрын төлбөр	599.1	678.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,026.5	1,030.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,672.3	88,256.1
120	Нийтлэг татварын бус орлого	57,672.3	88,256.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,842,090.6	3,117,311.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,766,204.9	3,044,651.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,766,204.9	3,044,651.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,860,135.5	2,164,315.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,271,843.0	1,403,101.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,617.9	181,401.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,756.0	260,982.1
2104	Хангамж, бараа материалын зардал	56,698.7	67,140.0
2105	Нормативт зардал	37,951.0	150,652.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,850.2	34,638.3
2107	Томилолт, зочны зардал	4,351.7	4,366.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,246.8	20,784.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,820.2	41,248.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	906,069.4	880,335.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	186,731.8	212,253.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	73,631.0	182,201.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,631.0	182,201.8
2200	Дотоод эх үүсвэрээр	73,631.0	182,201.8
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-73,631.0	-182,201.8




VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-28,000.0	-64,200.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	28,000.0	64,200.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	85,100.8	-34,148.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	130,517.9	215,618.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,618.7	181,470.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,290,867.2	3,290,867.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,290,867.2	3,290,867.2
9	Тайлант үеийн үр дүн	1,175,210.2	1,175,210.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,466,077.4	4,466,077.4
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,466,077.4	4,466,077.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,500.6	-1,500.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,464,576.8	4,464,576.8
19	Тайлант үеийн үр дүн	26,791.4	26,791.4
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,491,368.1	4,491,368.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,377,502.20	2,245,566.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,158,832.30	2,101,307.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,128,377.60	2,073,054.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,371.60	1,342,969.82




Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит


210101	Үндсэн цалин	1,065,377.60	1,025,984.01
210102	Нэмэгдэл	129,742.00	162,795.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,000.00	3,035.00
210104	Урамшуулал	120,786.50	112,628.66
210105	Гэрээт ажлын хөлс	44,465.50	38,526.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,594.60	174,896.71
210201	Тэтгэврийн даатгал	130,998.20	121,123.68
210202	Тэтгэмжийн даатгал	14,308.20	13,895.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,088.80	10,580.91
210204	Ажилгүйдлийн даатгал	2,747.30	2,686.16
210205	Эрүүл мэндийн даатгал	27,452.10	26,610.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,127.80	260,982.13
210301	Гэрэл, цахилгаан	9,256.50	8,265.54
210302	Түлш, халаалт	259,247.30	252,122.10
210303	Цэвэр, бохир ус	1,624.00	594.50
2104	Хангамж, бараа материалын зардал	58,991.10	58,166.07
210401	Бичиг хэрэг	7,044.50	6,664.65
210402	Тээвэр, шатахуун	40,808.30	40,817.29
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,140.80	3,714.53
210404	Ном, хэвлэл	129.00	127.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,560.00	1,549.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,308.50	5,293.50
2105	Нормативт зардал	77,229.40	68,330.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,526.70	13,169.41
210502	Хоол, хүнс	42,219.10	38,200.90



210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,483.60	16,959.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,369.00	118,126.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,022.80	48,997.90
210602	Тавилга	26,500.00	26,492.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	160.00	0.00
210604	Урсгал засвар	42,686.20	42,636.30
2107	Томилолт, зочны зардал	3,706.80	3,233.40
210702	Дотоод албан томилолт	3,706.80	3,233.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,118.00	12,624.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,370.60	9,426.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648.00	648.00
210803	Даатгалын үйлчилгээ	182.00	181.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117.90	117.85
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102.00	102.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	704.00	680.00
210807	Газрын төлбөр	285.70	285.69
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,320.00	875.50
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	387.80	306.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,869.30	33,725.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,643.60	24,542.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,225.70	9,183.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,454.70	28,252.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,454.70	28,252.60




213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,604.70	12,549.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,850.00	15,702.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,169.90	80,059.91
223001	Бусад хөрөнгө	138,169.90	80,059.91
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,500.00	64,200.00
230001	Эргэж төлөгдөх зээл	80,500.00	64,200.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,377,502.20	2,241,571.33
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,360,609.50	1,325,685.97
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,360,609.50	1,325,685.97
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	827,325.30	816,180.51
320001	Орон нутгийн төсвөөс	774,048.70	762,903.91
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	53,276.60	53,276.60
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,174.10	12,878.75
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,174.10	12,878.75
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	165,393.30	86,826.11
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000.00	62,788.54
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	24,037.57
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	147,295.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	143,300.06



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		225,368.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ		225,368.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		193,402.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		60,131.64
210101	Үндсэн цалин		60,131.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,504.91
210201	Тэтгэврийн даатгал		6,504.91
2104	Хангамж, бараа материалын зардал		8,973.90
210401	Бичиг хэрэг		118.00
210402	Тээвэр, шатахуун		8,235.85
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		620.05
2105	Нормативт зардал		82,321.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		69,405.24
210502	Хоол, хүнс		10,916.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		13,006.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,735.00
210604	Урсгал засвар		7,271.00
2107	Томилолт, зочны зардал		1,132.91
210701	Гадаад албан томилолт		0.00
210702	Дотоод албан томилолт		1,132.91
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,160.58



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,620.58
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		4,540.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13,171.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,661.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		31,966.09
2132	Бусад урсгал шилжүүлэг		31,525.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		31,525.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		441.09
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		226,648.22
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		226,648.22
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		7,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		43,719.38
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		23,208.84
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		151,970.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		1,279.26
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,279.26

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халиун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 2/43 дугаартай албан бичгээр ирүүлсэн боловч 2022 оны 03 дугаар сарын 24-ны байдлаар тайлан эцэслээгүй аудит ирүүлээгүй нь цаг хугацаа алдах үндэслэл боллоо.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн эрх ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах чиг үүрэг бүхий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нэгж юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт зардлын 2,310.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 46.2 сая төгрөгөөр, төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 36.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт зардлаас 3,507.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 70.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 56.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 52.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 215.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 181.6 сая төгрөг болж 34.0 сая төгрөгөөр буурсан сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нөлөөлсөн байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 333.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 439.5 сая төгрөг болж 106.4 сая төгрөгөөр өссөн нь сумын Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний

авлага, болон сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн авлагын үлдэгдэлтэй холбоотой.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 347.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 564.6 сая төгрөг болж 105.7 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 281.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 327.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 393.7 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,877.3 сая төгрөг болж 52.4 сая төгрөгөөр буурсан. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 209.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 107.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, 156.9 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 1.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11.1 сая төгрөг болж 9.9 сая төгрөгөөр өссөн нь эмийн зардлын өглөгтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,464.5 сая төгрөг болж 28.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 4492.6 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 51.3 сая төгрөгийн татварын орлого, 417.1 сая төгрөгийн татварын бус орлого, 3,225.9 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,507.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 3,507.1 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 221.2 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Халиун сумын ИТХ-ын 2021 оны 12 дүгээр сарын “Сумын 2020 оны төсөв тодотгон батлах тухай” 16 дугаар тогтоолд зааснаар Халиун сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 25.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 48.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 186.5 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс Бууны албан татвар 1.9 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.6 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.12 сая төгрөг, газрын төлбөр 0.6 сая төгрөг, торгуулийн орлого 1.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 2,377.5 сая төгрөгөөр баталсан байна

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,377.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас зардлын 1,360.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 774.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 53.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 24.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 135.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 224.5 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба ЗГНХ, ЗДНХөрөнгийн зардалд 3.5 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 72.2 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26.5 сая төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 124.9 сая төгрөгийг тус тус тайлагнасан зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Халиун сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансанд байршуулах мэдээллээс 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Халиун сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Шилэн дансанд байршуулах мэдээллээс 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Сум хөгжүүлэх сангийн төлөгдөөгүй актын үлдэгдэл 92.8 сая төгрөг байна. Халиун сумын Орон хөгжлийн санд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн 120.0 сая төгрөгийн төлбөрийн актаас 34.2 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй байгаад мэдэгдэл хүргүүлсэн байна. Мэдэгдэл ирүүлэх хугацаа болоогүй байгаа тул шийдвэр өгөөгүй болно.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно. Халиун сумын ЗДТГ-ын шийдвэрийн үлдэгдэл 64.2 сая төгрөгийг барагдуулаагүй байна. Байгууллагын нягтлан бодогч, төсөв захирагч солигдсон учир төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд мэдэгдэл хүргүүлээ.

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 3 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, дүгнэлт, хязгаарлалттай 2 санал дүгнэлт авсан байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 573.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 283.7 сая төгрөгийн алдааг залруулж, 11.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 277.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар 24.1 сая төгрөгийн зөрчил илэрч 11.4 сая төгрөгийн залруулга, 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 11.9 сая төгрөгийн албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:

Халиун сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:

Халиун сумын ИТХ-ын 5.4 сая төгрөгийн, Соёлын төвийн 2.9 сая төгрөгийн, Олонбулаг багийн ерөнхий боловсролын сургуулийн 2.9 сая төгрөгийн И баримтыг нөхөн тайлагнуулж аудитын явцад залрууллаа.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Халиун сумын нэгтгэсэн тайланд 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:

Төлбөрийн акт тогтоогоогүй болно

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс Бууны албан татвар 1.9 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.6 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.12 сая төгрөг, газрын төлбөр 0.6 сая төгрөг, торгуулийн орлого 1.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Засгийн газраас хөнгөлөлттэй олгосон усны төлбөр 0.7 сая төгрөгийг эцсийн санхүүгийн тайланд авлага тусгаагүй, тооцоо нийлээгүй нэхэмжилсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Халиун сумын ИТХ

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны /төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .."үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн

заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд Е баримтгүй 5.4 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ

Татварын тодорхойлолт 5.0 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Халиун сумын Соёлын төв

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны /төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ

Татварын тодорхойлолт 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Халиун сумын Олонбулаг багийн ерөнхий боловсролын сургууль

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны /төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ

Татварын тодорхойлолт 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллага хувьд

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Халиун сумын ИТХ

1.1 Илрүүлэлт: Шилэн дансанд байршуулах мэдээллээс 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Халиун сумын Соёлын төв

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд байршуулах мэдээллээс 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Халиун сумын Засаг дарга

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал

Халиун сумын ЗДТГ

2.1. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Халиун сумын Цэцэрлэг

3.1 Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16

дугар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Халиун сумын Ерөнхий боловсролын сургууль

- 4.1 Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 4.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Халиун сумын Олон булаг бага сургууль

- 5.1 Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 5.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
	Халиун сумын Төвлөрүүлэн захирагч	2	5.4			1	0.8	1	4.6	5	
Түүвэрт хамрагдсан байгууллага											
	Соёлын төв	3	3.2	1	2.9			2	0.3		
	Бага сургууль	3	5.0	1	2.9			2	2.1		
	ИТХ	3	10.4	1	5.4			2	5.0		
	Дүн	11	24.1	3	11.2	1	0.8	7	11.9	5	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1									
Соёлын төв	1								1	
ИТХ	1								1	
Дүн	2								2	
Нийт дүн	13	24.1	3	11.2	1	0.8	7	11.9	7	